

Э-ТРАНС
ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮС / ТАЛБАЙ /-ИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Э-Транс гаалийн хяналтын бүс, талбайд / цаашид хяналтын бүс гэнэ / Монгол улсын гаалийн тухай хууль, Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/294 тоот тушаалаар батлагдсан журам, заавруудад заасан үйл ажиллагаа эрхлэхэд энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Гаалийн хяналтын бүсэд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь Гаалийн төв байгууллагаас олгогдсон зөвшөөрөлд үндэслэгдсэн байна.

Хоёр. Гаалийн хяналтын бүсэд үйл ажиллагаа
явуулах нөхцөл шаардлага

2.1 Гаалийн хяналтын бүсэд үйл ажиллагаа явуулахад дараахь нөхцөл, шаардлагыг хангасан байна:

2.1.1. гаалийн хяналтын бүсэд орох, гарах хаалганаас бусад газраар бараа, тээврийн хэрэгсэл, бие хүн нэвтрэх боломжийг хаасан хашаа татсан,

2.1.2 гаалийн хяналтын бүс нь Монгол улсын стандарт / MNS 5832:2007/-д нийцсэн байх,

2.1.3 гаалийн хяналтын бүсийн хэмжээ нь гаалийн хяналт, шалгалт хийх шаардлага хангасан байх,

2.1.4. төмөр замын дагуу байрлах гаалийн хяналтын бүсэд ачиж, буулгах барааны хэмжээ, нэр төрөл, тээврийн хэрэгслийн тоог улирал бүрийн эхний сарын 10-ны дотор Замын Үүд дэх гаалийн байгууллагад өгч, сараар тодотгол хийх,

2.1.5. гаалийн байгууллагатай мэдээллийн сүлжээнд холбогдон гаалийн хяналтын бүсэд гаалийн хяналт тавихад шаардагдах техник, тоног төхөөрөмж суурилуулсан,

2.1.6. гаалийн хяналтын бүсийг олон нийтэд мэдэгдэхүйц таних тэмдэг хийж байрлуулах бөгөөд таних тэмдэг нь тэгш өнцөгт хэлбэртэй 1.0х0.60 метрийн харьцаатай, цагаан дэвсгэртэй самбар дээр хар хөх өнгөөр “Гаалийн хяналтын бүс” гэсэн бичээс бичих,

2.1.7. гаалийн хяналтын бүсэд болон гадна талд нь цэвэр үзэмжтэй самбарт тарифийн бус хязгаарлалттай бараатай холбогдол бүхий хууль тогтоомж, бүсийн дэглэм, төлбөр тооцоог олон нийтэд харагдахуйцаар бичиж, байрлуулсан байх;

2.1.8. компанийн гаалийн хяналтын талбайн эрхлэгч гаалийн хяналтын бүсэд оруулсан, гаргасан бараа, тээврийн хэрэгслийн мэдээг сар бүр гаргаж, дараа сарын 5-ны дотор хяналт тавьж буй гаалийн байгууллагад энэ журмын нэгдүгээр хавсралтаар баталсан маягтын дагуу гаргаж өгч байна.

Гурав. Гаалийн хяналтын бүсийн дэглэм

3.1. Гаалийн хяналтын бүс, талбайд нэвтрэхэд гаалийн байгууллагын зөвшөөрлийг үндэслэх бөгөөд гаалийн хяналтын талбайн эрхлэгч, компанийн харуул хамгаалалтын албаны ажилтан нартай хамтран хяналт тавина.

3.2. Бараа, тээврийн хэрэгслийн эзэмшигчийг гаалийн бүрдүүлэлт хийлгэх зорилгоор хяналтын бүсэд нэвтрүүлэхдээ харуул хамгаалалтын ажилтан нь биеийн байцаалтын баримт бичиг (үнэмлэх, паспорт)-ийг шалгаж нэвтрүүлнэ.

3.3. Бараа эзэмшигч, тээвэрлэгч гаалийн хяналтын бүсэд бараа, тээврийн хэрэгслийг оруулахдаа харуул хамгаалалтын ажилтанд тээврийн хэрэгслийн марк, улсын дугаарыг хэлж бүртгүүлнэ.

3.4. Барааг гаалийн хяналтын бүсэд оруулснаас хойш 3 хүртэл хоног зохих төлбөртэйгөөр хадгалах бөгөөд энэ хугацаанд гаалийн бүрдүүлэлт хийнэ.

3.5. Хяналтын бүсэд хадгалах хугацаа хэтэрсэн барааг түр агуулахад шилжүүлэх боломжгүй / жин тонн, овор хэмжээ ихтэй / тохиолдолд гаалийн нээлттэй түр агуулахад шилжсэнээр тооцож гаалийн хяналтын бүсэд хадгалах бөгөөд хадгалалтын хөлсөнд өөрчлөлт орно.

3.6. Хяналтын бүсэд оруулсан бараанд гаалийн бүрдүүлэлт хийж дууссан тохиолдолд гарах зөвшөөрлийг компанийн ачаа тээврийн албаас авах бөгөөд ачаа тээврийн алба гаалийн хяналтын бүсэд орсон огноог шалгаж үзсэний үндсэн дээр зөвшөөрлийг өгч гаргана.

Дөрөв. Гаалийн хяналтын бүс / талбай /-д мөрдөгдөх үнийн тариф

1. Талбай ашиглалт / Тээврийн хэрэгсэл /			
№	Үзүүлэлт		Дүн
1	Хоосон машин, тоног төхөөрөмжөөс бусад	Хоног тутамд	25000 төг
2	Хоосон машин, тоног төхөөрөмж	Өдөртөө багтааж бүрдүүлэлтээ хийгээд гарахад	10000 төг
3		Ачааг 1 хоног хадгалуулахад	25000 төг
4		Ачааг 2 хоног хадгалахад / эхний хоногийнх дээр нэмж /	20000 төг
5		Ачааг 3 хоног хадгалахад / эхний 2 хоногийнх дээр нэмж /	15000 төг
6		Ачааг 4 хоног хадгалахад / эхний 3 хоногийнх дээр нэмж /	10000 төг
2. Баталгаат агуулах			
1	24 цаг / хоног /	1 тн	1000 төг
3. Тавцан ашиглалт / тээврийн хэрэгсэл /			
1	Чингэлэг задалж буулгах		200000 төг
2	Машинаас тавцан руу шууд буулгах / 15 тонн хүртэл /		40000 төг
3	Тавцан дээр ачаа буулгаж шалгуулахад / төрөл бүрийн бараа /		25000 төг
4. Техник ашиглалт / Шилжүүлэн ачилт /			
1	Авто кран	Нэг өргөлт / бусад ачаа /	200000 төг
2		Цагаар ажиллахад / бусад ачаа /	250000 төг
3		Машинаас машин руу хоосон чингэлэг	120000 төг
4		20 тонны чингэлэг буулгаж ачихад	150000 төг
5		40 тонны чингэлэг буулгаж ачихад	250000 төг
6	Сэрээт ачигч 3 тн-ны	Нэг өргөлт	20000 төг
7		1 тн	10000 төг
8		Жин тонн 2,5-5 тонн хүртэлх эсхүл 15 байр хүртэлх ачааны 1 өргөлт	10000 төг
9	Сэрээт ачигч 5 тн-ны	Нэг өргөлт	40000 төг
10		1 тн	15000 төг
11	Автопүү	Ачаатай машин	20000 төг
12		Хоосон машин	10000 төг
5. Торгууль			

1	Гаалийн бүрдүүлэлт бүрэн хийгдэж, гарах хуудас авсан тээврийн хэрэгсэл гаалийн хяналтын бүсээс гараагүй хоносон тохиолдолд	50000 төг
2	Тавцан дээр машин тавьж хонуулсан тохиолдолд	25000 төг

Тав. Хяналтын бүсэд үйл ажиллагаа явуулагчийн эрх үүрэг.

5.1. Хяналтын бүс, талбайг байнгын хариуцан ажиллах ажилтанг захирлын тушаалаар томилж ажиллуулах,

5.2. Хяналтын бүсэд гаалийн бүрдүүлэлт хийхээр нэвтэрсэн тээврийн хэрэгслийн бүртгэлийг өдөр бүр шинэчилэн бүртгэж, бүртгэл нь гаалийн хяналтын талбай, баталгаат агуулах хариуцсан гаалийн байцаагчийн бүртгэлтэй тулгаж байх.

5.3. Харуул хамгаалалтын ажилтнуудыг ажлын цагаар байнгын хяналт тавьж удирдлагаар хангаж ажиллах,

5.4. Харуул хамгаалалтын ажилтан нарын бүртгэлийг хянаж үзэж байх.

5.5. Гаалийн байгууллагад тогтоосон хугацаанд тайлан мэдээг гаргаж хүргэж байх.

5.6. Хяналтын талбайгаас гарч байгаа ачаа бараа, тээврийн хэрэгслүүдийн талбай ашигласны хөлсийг бодож тооцоог хийж дууссаны дараа гарах зөвшөөрлийг олгож байх бөгөөд тооцоогоо өгөөгүй, өгөхөөс зайлсхийсэн, тооцоотой холбоотой ямар нэгэн асуудал үүссэн бол холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу шийдвэрлүүлэх,

Зургаа. Харуул хамгаалалтын албаны эрх үүрэг.

6.1. Гаалийн хяналтын бүсэд зөвшөөрөлтэй хүн, бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх,

6.2. Хяналтын бүсэд нэвтэрсэн тээврийн хэрэгсэл, ачаа барааг бүртгэж хүлээж авч байх,

6.3. Хяналтын талбайд техник, тоног төрөөрөмж, ачаа бараа, тээврийн хэрэгслийг байрлуулахдаа аль болох эмх цэгцтэй, талбайн багтаамжийг харж байрлуулах бөгөөд мөргөж шүргэх зэрэг эвдрэл гэмтэл гаргахгүй байхад онцгой анхаарч ажиллах,

6.4. Хяналтын талбайд зөвшөөрөлгүй, согтууруулах ундаа хэрэглэсэн этгээдийг нэвтрүүлэхгүй бөгөөд шаардлагатай тохиолдол гарвал цагдаагийн байгууллагыг дуудаж асуудлыг шийдвэрлүүлж байх,

6.5. Хяналтын талбайд 24 цагаар үүрэг гүйцэтгэж байгаа харуул хамгаалалтын ажилтан нар нь шөнийн цагаар хяналтын талбайг 30 минут тутам эргэж, тухайн өдөр үүрэг гүйцэтгэж байгаа пүүлэгчид станцаар мэдээ өгч байх,

6.6. Хяналтын талбайгаас ачаа бараа, тээврийн хэрэгслийг гаргахдаа заавал зөвшөөрлийн хуудсыг шалгаж үзсэний үндсэн дээр гаргах бөгөөд хэрэв зөвшөөрөлгүй тээврийн хэрэгслийг гаргасан байвал тухайн ээлжинд гарсан ажилтан өөрийн зардлаар тооцоог хийж дуусгана.

Долоо. Гаалийн хяналтын бүсэд дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

7.1. Гаалийн хяналтын бүсэд зөвшөөрөгдсөнөөс бусад газраар нэвтрэх, бараа, тээврийн хэрэгсэл, хүн нэвтрүүлэх;

7.2. Гаалийн хяналтын бүсэд гаалийн байгууллагын зөвшөөрөлгүй бараа, тээврийн хэрэгсэл, хүн нэвтрүүлэх;

7.3. Гаалийн байгууллагаас зөвшөөрснөөс бусад үйл ажиллагааг явуулах;

7.4. Гаалийн хяналтын бүс, гаалийн хилийг тодорхойлсон анхааруулга, тэмдгийг эвдэх, гэмтээх, өөрчлөх, хяналтын бүсэд нийгмийн хэв журам алдагдуулах;

7.5. Гаалийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр аж ахуйн зориулалтаар байр талбай түрээслүүлэх, аж ахуйн үйл ажиллагаа явуулах.

Найм. Бусад

7.1. Гаалийн хяналтын бүсэд хадгалагдаж буй бараа алдагдсан, гаалийн байгууллагын зөвшөөрөлгүй олгогдсон, устгагдсан бол тухайн бараанд ногдох гаалийн болон бусад татварыг гаалийн хяналтын бүс тогтоолгосон аж ахуйн нэгж байгууллага төлнө.

7.2. Гаалийн хяналтын бүсийн дэглэм зөрчсөн тохиолдолд гаалийн хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

7.3. Гаалийн хяналтын бүсэд гаалийн түр агуулах байгуулж болно.

7.4. Энэхүү журмаар зохицуулагдаагүй бусад асуудлыг гаалийн тухай хууль тогтоомж болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Э-ТРАНС ЛОЖСИТИК ХК ДАХЬ ГААЛИЙН ХЯНАЛТЫН
БҮСЭД НЭВТЭРСЭН БАРАА, ТЭЭВРИЙН
ХЭРЭГСЛИЙН МЭДЭЭ

_____ он _____ сар _____ өдөр

д/д	Манифестийн дугаар	Тээврийн хэрэгслийн дугаар	Тээврийн баримтын дугаар	Чингэлэг №	Буусан он, сар, өдөр	Бараа хүлээн авагч	Барааны нэр	Гаалийн мэдүүлэг

Мэдээ гаргасан: _____

/ Байгууллагын тэмдэг дарсан байна/